



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/89

Мөрөн сум

Дуудлага худалдаа дахин зохион  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн хуулийн 197 дугаар зүйлийн 197.23, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 20 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус X хуралдааны 2022 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөвсгөлийн Эмийн Эргэлтийн Сан" ОНӨХК-ийн Алаг-Эрдэнэ, Тариалан, Чандмань-Өндөр суман дахь эмийн сангийн эд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдаанд ялагч болсон этгээдүүд гэрээний үүргээ биелүүлээгүй, хуулийн хугацаанд гэрээ байгуулахаас эс үйлдэхүйгээр татгалзсан, үнэ хаялцсан дараагийн этгээд гэрээ байгуулахаас татгалзсан тул хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль журмын дагуу дахин зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

2. Дуудлага худалдааг нээлттэй ил тод шуурхай зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН